

~ Японы талаар илүү сайн мэдэж авцгаая ~

2024 оны 1 дугаар сар,
Өвлийн дугаар

Сэдэв

Мангагаар дамжуулан мэдэж авцгаая. Улирлын арга хэмжээ "節分 (сэцүбүн)"

◇~Японы шинэ жил~ 書初め (какизомэ)-д өөрийгөө сорьж үзэхийг санал болгож байна.

◇Японы үндэсний спорт "相撲 (сүмо)"

こくごのもり/kokugo no mori/"Үг холбох"

Tìm hiểu sự kiện và thời tiết qua truyện tranh manga

— 節分 (сэцүбүн) —



Японы уламжлалт ёс заншил, сэцүбүн

2-р сарын 3 бол сэцүбүн. "Чөтгөр цаашаа! Аз жаргал наашаа!" гэж хэлэнгээ буурцаг цацаж, муу энергийг хөөж, шинэ оныг угтдаг ёс заншил юм. Өөрийнхөө хий нас (Одоогийн нас+1)-тай ижил тооны буурцаг идэж, эхомаки идэхдээ хүслээ дотроо бодож, юм ярилгүйгээр иддэг. Эхо (аз жаргалтай болдог гэгдэх зүг) зүг рүү харж идээрэй. 2024 оны эхо бол зүүн, зүүн хойдын дундын зүг.

"とも/Томо" нь, Японд амьдрахад хэрэг болох мэдээлэл, Япон хэл сурахад хэрэг болох зүйлс зэргийг, дуудлагыг нь хадсан Япон хэл болон гадаадын 9 орны хэл (Вьетнам, Хятад, Филиппин, Индонези, Тайланд, Камбодж, Мьянмар, Монгол, Англи) дээр гаргадаг. Япон хэл дээрх хувилбарыг товхимол хэлбэрээр хүргэдэг ба гадаад хэл дээрх хувилбарыг JITCO-гийн цахим хуудаснаас ухаалаг утас зэргийг ашиглан, PDF хэлбэрээр харах боломжтой. Та бүхэнд орж харахыг санал болгож байна.
(<https://www.jitco.or.jp/ja/tomo/>)





~Японы шинэ жил~

какизомэ-д өөрийгөө сорьж үзэхийг санал болгож байна.

какизомэ нь Японы шинэ жилийн ёс заншлуудын нэг бөгөөд оны эхэнд бичиг бичих, зураг зурахыг хэлнэ. Шинэ онд тавих зорилт болон хичээх зүйлээ илэрхийлэх үг, эрүүл мэнд, аз жаргалыг хүсэх хэлц үгийг бэх, бийр хэрэглэж бичдэг. Та бүхэнд ч гэсэн энэ жилийн зорилт, ирээдүйн мөрөөдөл зэргээ том цаасан дээр бичиж үзэхийг санал болгож байна.



1-р сарын дугаараар, жил бүр какизомэ тэмцээн зохион байгуулдаг Ай-ой дэнши когёд ажилладаг Вьетнамаас ирсэн 2 хүнтай ярилцлаа. “Тус компани нь какизомэ-гээс гадна “Насанд хүрсний ёслол”, “Оханами”, “Гүзээлзгэнэ түүх”, “Салют буудуулах” зэрэг жилийн турш төрөл бүрийн арга хэмжээнүүд зохион байгуулдаг. Японы соёлтой биечлэн танилцсанаар, Японы талаарх ойлголт нь гүнзгийрч, илүү сайн харилцаа бий болоход түлхэц болж байна.” хэмээн тус компаний Генго Яжима захирал ярил.



Хамтран ажилласан : 相生電子工業株式会社 (神奈川県高座郡寒川町)



元工の元手
シン

(Өөрийн гар бичвэр)

■Яагаад “成長 (сэйчо/өсөлт хөгжил)” гэж бичсэн бэ?

—Японд ирээд 4 жил болж, янз бүрийн зүйл суралцаж, өөрийгөө өсч хөгжсөн гэж мэдэрсэн учраас сонгосон.

■Бэх, бийр хэрэглэж бичсэн сэтгэгдлээ хуваалцана уу.

—Анх удаа бийр хэрэглэж үзсэн. Вьетнамд ч бийр байдаг боловч түгээмэл хэрэглэдэггүй. Эхэндээ цаас нь урагтчихаад, бичихэд хэцүү байсан.

■Одоо юу сонирхож байна?

—Аялах дуртай. Гифү мужийн Ширакава-го явахад, цас хараад сэтгэл хөдөлсөн.

■Японд ирээд хэцүү байсан зүйл байгаа юу?

—Гэр бүлтэйгээ уулзах боломжгүй нь уйтгартай байсан. Одоо бол амралтын өдрөөрөө видео кол хийдэг.

■Ирээдүйн мөрөөдөл, зорилтоо хуваалцана уу.

—Вьетнамд харихаараа Японд сурсан зүйлээ ашиглаж ажил хийх хүсэлтэй байна.

■Яагаад “団結(данкэцү/нэгдэх)” гэж бичсэн бэ?

—“Олон хүмүүс сэтгэлээрээ нэгдэж, ижил зүг рүү чиглэн хичээн чармайж байна” гэдэг утгатай үгийг сонгосон.

■Бэх, бийр хэрэглэж бичсэн сэтгэгдлээ хуваалцана уу.

—Анх удаа бийр хэрэглэж үзсэн. Гоё бичих нь маш хэцүү, загвар харангаа дахин дахин бичсэн.

■Японд ирээд сэтгэл хөдөлсөн зүйл байгаа юу?

—Вьетнам бол жилийн турш бороо ихтэй, халуун байдаг ч Японд хавар, зун, намар, өвөл гэсэн 4 улирал байдаг нь.

■Ямар Япон хоолонд дуртай вэ?

—Осүшид дуртай. Гэхдээ түүхий хоолонд тийм сайн биш. Натто/даршилсан шар буурцагт дуртай.

■Японд ирээд Японы талаар мэдэрсэн зүйлээ хуваалцана уу.

—Японд дуртай болохоор Японд ирсэн. Ирэхээсээ өмнө мэдээгүй боловч Япон хүн ч гэсэн эелдэг хүн, хэцүүхэн хүн, ажилд хатуу хүн г.м янз бүр. Вьетнам хүнээс өөр үзэл бодолд гайхах тохиолдол ч байсан. Гэхдээ амьдрах явцдаа Япон хүнд ч, Японы үзэл бодолд ч бага багаар дасч ирсэн.



フアン ティ ミー フェン

(Өөрийн гар бичвэр)

JITCO нь төрөл бүрийн “Япон хэл сурахад зориулсан сурах бичиг” худалдаалж байна. Ур чадварын дадлагын талбарт түгээмэл тохиолддог харилцан яриаг түлхүү суралцах боломжтой текст ч байгаа. “JITCO, сурах бичгийн онлайн дэлгүүр”-ийн сайтаар заавал орж үзээрэй. <https://onlineshop.jitco.or.jp/>



Японы үндэсний спорт “сүмо”

сүмо нь Японы онцлог тулааны урлаг/тэмцээн бөгөөд уламжлалт соёл юм. Үүнийг “үндэсний спорт” гэж хэлдэг. Гарал үүсэл нь маш эртний ба домгийн үеэс эхлэлтэй.

сүмо нь анх арвин ургац хураахыг залбирах баярын үеийн ёслол болж Япон даяар дэлгэрсэн. Мөн, одоогоос 800 гаруй жилийн өмнөөс 400 орчим жилийн өмнө хүртэлх “Самурайгийн үе”-д тулааны сургуулалт болж түгсэн. Тэгээд, энх тайван үе ирэхэд, тэмцээн болж, сүмо барилдахыг ажил мэргэжил болгосон хүмүүс “Сүмо бөх” бий болон, мөнгө төлж үздэг энтертейнмент болж, хүмүүсийн сонирхлыг татах болсон.

Түүхийн урт хугацаанд тэмцээний дүрэм бий болохын зэрэгцээ Сүмо бөхийн гадна төрх болон ахуй амьдрал, нийгэмтэй хамаарах хамаарал зэрэг нь соёл болон төлөвшиж, өнөөг хүртэл үргэлжилж ирсэн. Урт үсээ нэгтгэж, зулай дээрээ бэхэлдэг “чонмагэ” гэгддэг үсний загвар нь ойлгомжтой жишээ юм.

Зөвхөн сүмо-гийн ертөнцөд хэрэглэгдэж байсан үг хэллэг нь Япон хүн ердийн үеэс их хэрэглэдэг үг хэллэг болсон тохиолдол олон байдаг. Тухайлбал, “がちんこ (гачинко)”. Жинхэнээсээ тулалдах тулааныг “гачи тулаан” гэж ярьдаг нь угтаа бол 相撲-гийн хэллэг юм. Дараа нь, “土俵際 (дохиогива)”. сүмо барилдах дэвжээ нь дугуй хэлбэрийн заагтай ба энэ заагаас хальж, гадагшаа гарвал ялагддаг. Үүнээс улбаатайгаар, ямар нэг зүйл яг шийдэгдэх гэж байгаа мөчийг дохиогива гэж хэлдэг. Төгсгөлд нь,

“千秋楽 (сэншюраку)”. сүмо-гоос гадна кино, жүжиг г.м энтертейнментийн сүүлчийн өдрийг илэрхийлнэ. Эдгээрээс гадна, “序ノ口 (жонокүчи)”, “死に体 (шинитай)”, “力水 (чикара-мизү)”, “水入り (мизү-ири)”, “ぶちかまし (бүчикамаши)” зэрэг хэллэгүүд ч, угтаа бол 相撲-гийн хэллэгүүд юм. Утгыг нь судалж үзвэл сонирхолтой байх болов уу.

Токио, Нагоя, Осака, Фүкүокад болдог жилд 6 удаагийн 本場所 (хон-башо)-гоор, өдөрт 100-гаас дээш барилдаан (тэмцээн) болдог ба ээлж дараалан гарч ирэх Сүмо бөх нь өдөрт зөвхөн 1 барилддаг, энэ нь 15 өдөр үргэлжилдэг, дэлхийн спортуудын дотор ч маш ховор системтэй юм. Мөн, улс дотор олон газруудад болдог энтертейнментийн Сүмо бөхчүүд нь хүмүүст маш дотно санагддаг. Тийм болохоор, Сүмо бөхчүүийг дотночилж, “お相撲さん (осүмо сан/Сүмо гуай)” гэж дууддаг. Бэйсболын тамирчдыг “お野球さん (оякү сан/бэйсбол гуай)” гэж дууддаггүй биз дээ.

Бие нь биетэйгээ, толгой нь толгойтойгоо хүчтэй мөргөлдөж, тэр дуу чимээ нь ордноор дүүрэн цуурайтдаг сүмо үзэхэд эрч хүчээр дүүрэн байдаг. Заавал биечлэн үзэж сонирхоорой.



Кокуго-но-мори

Энэ нь Япон хэлний үг хэллэг, ханз болон эдгээрийн хэрэглэх аргын талаар суралцахад зориулсан сурах бичиг болно. Зугаатайгаар хариуг нь бодож олцгооё. (Хариу нь дараагийн хуудсанд байгаа.)

とにをの
がへもで

①上と下の言葉をつなぐ一字の言葉をえらんで書きましょう。

ど	弟	だ	か	バ	七	に	ノ
こ	い	れ	ぜ	ス	時	こ	ト
行	わ	い	休	つ	お	か	え
こう	ら	ない	む	く	きる	さ	ん
か	わ	い	む	く	る	さ	び
	せ	い	む	く	る	さ	つ

言葉をつなぐ

Инээмсэглэсэн зураг



Мьянмарын үндэсний хувцас лонги өмссөн дадлагажигч нар. Сэнсоожи хийдийн өмнө авсан дурсгалын зураг нь цэлмэг тэнгэрийн доор, дөлгөөхөн инээмсэглэл дүүрэн. Энэ өдөр эзэн хааны ордны өмнөх Нижюбаши гүүрээр зугаалан, Токиогийн буланд аяллын хөлөг онгоцонд сууж, хүсч байсан Токиогийн цамхаг, Токио скай три цамхаг руу ч явж, олон дурсгалтай болж чадлаа.

※2023年7月投稿 (監理団体：TNK協同組合、実習実施者：株式会社兼藤)

Ур чадварын дадлагажигчийн хүлээн авагч байгууллагуудаас JITCO-гийн цахим хуудсанд ирүүлсэн “Ур чадварын дадлагын Days”-ээс нэг зургийг сонгон нийтэлж байна. “Ур чадварын дадлагын Days” хуудас болон зураг ирүүлэх удирдамжийг эндээс харна уу.

(<https://www.jitco.or.jp/ja/days/>)



Зөвлөгөө өгөх цонхны танилцуулга

[Асуудал тулгарсан үед ...?](https://www.otit.go.jp/notebook/) (<https://www.otit.go.jp/notebook/>)

ОТИТ (Гадаад иргэдийн ур чадварын дадлагын байгууллага)-ын “Асуудал тулгарсан үед ур чадварын дадлагажигчдын эх хэл дээр нь зөвлөгөө өгөх цонх” болон бүс нутгийн зөвлөгөө өгөх цонх, гамшгаас сэргийлэх мэдээлэл, хэрэг болох аппликейшн “げんばの にほんご /Гэнба но нихонго/Ажлын байранд хэрэглэх Япон хэл”, “Ур чадварын дадлагажигчдад зориулсан гарын авлага” зэргийг ашиглах боломжтой.



Үгэнд янз бүрээр үйлчилдэг жижиг бөгөөд чухал үг нь залгавар юм. Үгийн ард залгадаг ба бусад үгтэй хамаарах хамаарлыг нь заах, тухайн үгэндээ утга нэмэх зэргээр үйлчилдэг.

Дээрхээс гадна “кара, кэрэдо, косо, саэ, ходо.....” г.м залгаврууд байдаг ба эдгээр нь үгнүүдийг холбох чухал холбогч нь болдог.

とも

2024年1月 冬季号

2024年1月1日発行

発行

公益財団法人 国際人材協力機構 (JITCO)

総務部広報室

〒108-0023

東京都港区芝浦2-11-5

五十嵐ビルディング

電話

03-4306-1166 (ダイヤルイン)

JITCO ホームページ

<https://www.jitco.or.jp/>